



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/08

Өвт

Цэргийн тоо бүртгэл явуулах тухай.

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалт, 34 дүгээр зүйл, Аймгийн Засаг даргын 2020 оны А/01 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2020 оны цэргийн тоо бүртгэлийг 2020 оны 01 дүгээр сарын 15-аас 2020 оны 01 дүгээр сарын 30-ны дотор зохион байгуулсугай.

2. Цэргийн тоо бүртгэл явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Н.Бат-Эрдэнэ-Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: Т.Жамъянжав-1 дүгээр багийн Засаг дарга

Д.Даваацэрэн-2 дугаар багийн Засаг дарга

С.Төмөр-3 дугаар багийн Засаг дарга

Г.Пүрэвтогтох-4 дүгээр багийн Засаг дарга

Л.Балжинням-5 дугаар багийн Засаг дарга

Б.Орбиш – Нийгмийн ажилтан

Г.Сарантуяа-Архив, бичиг хэргийн эрхлэгч

Г.Дуламдорж-Насан туршийн боловсролын арга зүйч

3. Цэргийн тоо бүртгэлийг зохион байгуулахдаа иргэдэд зар мэдээллийг хүргэн, иргэний цахим үнэмлэх, цэргийн үүрэгтний үнэмлэхийг үндэслэн бүртгэхийг багийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Цэргийн тоо бүртгэлийг Соёлын төвийн байранд заасан хугацаанд заавар журмын дагуу явуулж, дүн мэдээг 2020 оны 02 дугаар сарын 06-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт хүлээлгэн өгөхийг ажлын хэсгийн ахлагч (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

5. Цэргийн тоо бүртгэл зохион байгуулахад шаардагдах 200000 /Хоёр зуун мянган/ төгрөгийг Засаг даргын Тамгын газрын хичээл үйлдвэрийн дадлагын зардлаас зарцуулахыг Санхүүгийн албаны нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

М.ЖАМЪЯНШАРАВ

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

051010015